

ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ АСУУДАЛД

Д.Одбилэг* Д.Дуламсүрэн** Н.Баянтөр***

Хураангуй: Зэрэглэл нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах түүний бүх оролцогчдын эрх ашгийн нэгдэл болдог ба уг зах зээлд оролцох, сонголт хийх боломжийг нийтэд харуулдаг зах зээлийн нэн чухал үзүүлэлт юм.

Сүүлийн жилүүдэд зээлжих зэрэглэлийн ач холбогдол өсч, тэр ч хирээр зээлжих зэрэглэлээ тогтоолгох эрэлт өсч байна. Учир нь хөрөнгө оруулагчдын үндсэн шалгуур болгон хардаг үзүүлэлт “Тухайн улсын зээлжих зэрэглэл” болоод байна. Зээлжих зэрэглэл нь тухайн улсын болон компанийн эрсдэлийг тодорхой аргачлалын дагуу гарган үнэлгээ өгч хөрөнгө оруулалтад шаардагдах өгөөжийг харгалзуулан тодорхойлдог байна. Үүнээс гадна зэрэглэл нь байгууллагуудын авах зээлийн зардалд хэрхэн нөлөөлж байна вэ? Эдгээр асуултуудыг судлахын тулд бид дэлхийн хамгийн том гурван зэрэглэл тогтоогч байгууллага болох Moody’s Investors Service, Standart and Poor’s болон Fitch-н гаргадаг зэрэглэлийг тодорхойлдог хүчин зүйлс дээр системт анализ хийсэн болно.

Харин Монгол улсад зээлжих зэрэглэлийг тогтоох тухай багц асуудал институтын хувьд хөгжлөө олоогүй хэрэглэгч, оролцогчдод ялангуяа компаниуд энэ талаар төлөвшиж чадаагүй байна. Иймээс компаниуд зээлжих зэрэглэлээ тогтоохын тулд олон улсын мэргэжлийн байгууллагад хандахаас зайлшгүй бөгөөд энэ нь маш өндөр өртөгтэй үйлчилгээ байдаг. Нөгөө талаас санхүүгийн зах зээлээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх сонирхолтой иргэд, сан гэх мэт олон субъектүүд бодитой мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байна. Энэ нь манай хөрөнгийн зах зээлхөгжихгүй, хөрөнгө оруулалт дорвитой нэмэгдэхгүй байгаагийн нэг шалтгаан юм.

Компаниудын санхүүгийн тайлагнал, мэдээллийн хариуцлагыг дээшлүүлж хөрөнгө оруулагчдыг шаардлагатай мэдээллээр хангах асуудлын нэг зэрэглэл тогтоох

* МУИС-ийн, Бизнесийн сургуулийн багш, (E-mail) bilgeebts@yahoo.com

** МУИС-ийн, Бизнесийн сургуулийн зөвлөх профессор, (E-mail) ddulam@yahoo.com

*** МУИС-ийн, Бизнесийн сургуулийн багш, (E-mail) bayanturn@yahoo.com


үйлчилгээг нэн даруй эхлүүлэх явдал юм. Уг судалгааны ажлаар зэрэглэл тогтоох үйлчилгээг Монголын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх асуудлыг судалж компаниуд зэрэглэл тогтоох нийтлэг үндэслэлийг авч үзлээ.

Түлхүүр үг: Зээлжих зэрэглэл, зэрэглэл тогтоох

Удиртгал

Зээлжих зэрэглэл жил ирэх тусам тухайн улсын тулгамдсан асуудлуудын нэг болж байна. Учир нь зээлжих зэрэглэл сайн байх тусам хямд Эх сурвалж татах боломжтой болдог. Хямд Эх сурвалж татсанаар зардлыг минимумчилж, өртөг багасч эдийн засгийн үр ашигтай ажиллах боломжтой юм.

График 1. Зэрэглэлийн эерэг сөрөг мэдээлэл гарсны дараах ЗГ-ын бондын хүүний өөрчлөлт



Эх сурвалж: Bloomberg L.P, J.P Morgan, Дэлхийн банк

Дээрхи графикаас харахад Moody's болон S&P-ээс зэрэглэлийн талаар эерэг мэдээлэл хэвлэлүүдээр цацагдахад тухайн улсын засгийн газрын бондын хүү даруй буурч байсан бол харин сөрөг мэдээлэл цацагдсан үед бондын хүү өссөн шинжтэй ажиглагдаж байна.

Ийнхүү бондын хүү өсч буурахад нөлөөлөх хүчтэй хүчин зүйл нь Moody's болон S&P-н гаргасан зэрэглэл, түүнтэй холбоотой эерэг болон сөрөг мэдээлэл байх бөгөөд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал нөлөө үзүүлэгч зээлийн хүүгийн нам түвшинд очиход зээлжих зэрэглэлийн өндөр түвшин ихээхэн нөлөө үзүүлэх юм.

Нөгөө талаас тухайн улсын зах зээл дээр бүрэн тогтносон хүчтэй

байгууллагууд олон улсын зах дээр бонд гаргахад хөрөнгө оруулагчдын хувьд Moody's болон S&P-н зэрэглэл тогтоолгосон эсэх болон зээлжих зэрэглэл нь аль түвшинд байгааг анхааран бондын хүүг тогтоодог ба тухайн байгууллагын зэрэглэл өндөр гарч болох ч хэзээ ч тухайн улсын зэрэглэлээс давдаггүй. Төр болон хувийн хэвшлийнхэн урт хугацаанд бага хүүтэй Эх сурвалжийг татсанаар урт хугацааны тогтвортой санхүүгийн загварчлал, санхүүгийн төлөвлөгөө гарган эрсдэл багатай үйл ажиллагаа явуулах боломж бүрддэг.

Тиймээс тухайн улсын зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан, зээлжих зэрэглэлийг өндөр болгохын тулд одооноос эхлэн засгийн газар болон хувийн хэвшлийнхэн юун дээр анхаарахыг тодотгох нь зайлшгүй тулгамдсан асуудал болоод байна.

Зээлжих зэрэглэлийг тогтоохдоо улсаар, байгууллагаар мөн тэдгээрийн гаргаж буй өрийн үнэт цаасанд тус тусад нь тогтоох бөгөөд тэдгээрийн засаглал, эдийн засаг, төсөв санхүүгийн үзүүлэлтийг нэгтгэн тооцоолдог.

Өнөөг хүртэл 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Зээлийн мэдээллийн тухай хуулийн 14.1.3-т “зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох”, 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.14-т “санхүүжих чадавхийн зэрэглэл” тогтоох үйл ажиллагааг эрхэлж болохоор зааж Монгол Улсын санхүүгийн зах зээл дээр анх удаагаа зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээний эрх зүйн орчинг бий болгосон бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2010 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 97 дугаар тогтоолоор “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 529 дүгээр тогтоолоор “Санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ыг тус тус баталж, эрх зүйн зохицуулалтыг улам тодорхой болгосон.

Гэвч зэрэглэл тогтоох үйлчилгээ манай улсад хөгжөөгүй, энэ талаарх ойлголтууд нь олон нийтэд төлөвшөөгүй байгаа нь манай санхүүгийн зах зээлд энэ чиглэлийн байгууллагууд бараг байхгүй байгаагаар харагдаж байна.

Зэрэглэл

“Зэрэглэл” гэж хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүний аливаа өр төлбөр, түүнтэй адилтгах өрийн бичгийн ирээдүйд төлбөр төлөх чадварын богино болон дунд хугацааны төлөв байдал, төсөөллийг тодорхойлох замаар

тухайн байгууллагад өгсөн үнэлэлт, дүгнэлтийг хэлнэ⁴.

Зэрэглэл тогтоох байгууллага

Зээлжих зэрэглэлийг тогтоох мэргэжлийн байгууллага нь хөрөнгө оруулалтыг татаж буй компани нь үнэт цаас гаргаснаар хүлээсэн санхүүгийн үүргээ хугацаандаа дуусгаж чадах эсэх талаар төсөөллийг хөрөнгө оруулагчдад хамгийн бодитойгоор өгч чадах үйлчилгээ үзүүлэгч юм. Иймээс тухайн байгууллага нь санхүүгийн зах зээлийн хамгийн чухал хэсэг байх ёстой. Манайд;

“Зэрэглэл тогтоох арга, аргачлалыг ашиглан аливаа хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүний санхүүгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор байгуулагдаж Хорооноос эрх авч үйл ажиллагаагаа бүртгүүлсэн хуулийн этгээд юм⁵ гэж заасан байдаг.

Олон улсад зээлжих зэрэглэл тогтоодог олон компаниуд байдаг боловч тэдгээрээс нэр хүнд бүхий дараах 3 агентын зэрэглэл тогтоосон байдал болон зэрэглэл тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг танилцуулж байна. Үүнд:

1. Стандарт энд Пүүрс /Standard and Poor's/⁶- 6300 ажилтантай, 26 улсад салбартай, 150 жилийн туршлагатай Нью-Йорк болон Лондон хотод төвтэй 90 улсад 1500 гаруй ажилтантай томоохон агент юм. 100 гаруй улсын 34 триллион ам.доллар өрийн зэрэглэлийг тогтоосон ба үүнээс:
 - 3100 санхүүгийн байгууллагууд, 1600 банк, 1400 даатгалын банк, 1200 аж ахуй нэгж байгууллага, 45000 орон нутгийн шилжүүлэг, Европын 1200, Азийн 200-д санхүүгийн үйл ажиллагааны зэрэглэлийг тогтоосон байна.
2. Мооди /Moody,s/⁷- Дэлхий даяар нийт 2400 ажилчинтай бөгөөд 1000-нь шинжээчид байдаг. Тухайн байгууллага нь 2015 онд 3,5 тэрбум долларын орлоготой байсан бөгөөд 36 улсад салбарт нь 10800 орчим ажилтан ажилладаг. Тэдний түүхээс харуулбал:
 - Дэлхийн 2400 гаруй байгууллага, 120 гаруй тусгаар улс үндэстэн, 11000 компани, 25000 төрийн байгууллага, 72000 бүтэцлэгдсэн санхүүгийн гэрээнүүд, 170000 байгууллага, засгийн газар ба санхүүгийн хэрэгслүүдийн зэрэглэлийг тогтоосон.
3. Фич /Fitch/⁸-1914 онд Фич хэвлэлийн компани үүсгэн байгуулагдсанаар Фич /Fitch/ группын өнөөгийн өндөрт хүрсэн бөгөөд одоогоор Нью-

4 “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам” 2013 он

5 “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам” 2013он

6 www.standardandpoors.com

7 www.moody.com

8 <https://www.fitchratings.com>

Йорк, АНУ, Лондон, Их Британи улсадтөвтэй ойролцоогоор 2000 гаруй ажилтантай.

1975 оноос хойш АНУ-ын үнэт цаас, биржийн хорооноос дээрх 3 зээлжих зэрэглэл тогтоодог агентуудыг үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн үнэлгээний байгууллага гэж зарласан байдаг⁹.

Зэрэглэлийн төрөл

Улсын зээлжих зэрэглэл: Тухайн улсад хөрөнгө оруулахад үүсэх эрсдэлийн түвшинг илэрхийлдэг бөгөөд үүнд улс төрийн эрсдлийг мөнтөөцөөлдөг.

Улсын зээлжих зэрэглэл нь тухайн улсын засгийн газрын болон удирдах байгууллага макро эдийн засгийн байдал, институцийн чадвар, өр төлөх чадвар зэрэгт оноо үнэлгээ хийдэг. Энэхүү оноо өгч зэрэглэл тогтоох аргачлал нь улсын зээлжих зэрэглэлийг тодорхойлоход үндсэн 5-н үзүүлэлтийг тооцож гаргадаг. Үүнд:

Хүснэгт 1. Улсын зээлжих зэрэглэлийг тодорхойлох үндсэн 5-н хувьсагчийн оноо

Зэрэглэлийн хувьсагчдын түлхүүр	Хувьсагчдын оноог тодорхойлох нь, “1”- хамгийн хүчтэй, “6”- хамгийн сул
Институцийн үр ашиг ба улс төрийн эрсдэл	Улс төрийн оноо
Эдийн засгийн стратеги ба өсөлтийн хэтийн төлөв	Эдийн засгийн оноо
Гадаад хөрвөх чадвар ба олон улсын хөрөнгө оруулалтын байдал	Гадаад байдлын оноо
Санхүүгийн уян хатан байдал ба санхүүгийн гүйцэтгэл, төсвийн өрийн хамтаар	Санхүүгийн оноо
Мөнгөний бодлогын уян хатан байдал	Мөнгөний бодлогын оноо

Эх сурвалж: Standard and Poor’s “Sovereign Credit Rating Methodology”

Тухайн улсын зээлжих зэрэглэлийг тогтооход улс төрийн байдал, макро эдийн засгийн байдал, хэтийн төлөв, гадаад байдал, санхүүгийн байдал болон

⁹ https://en.wikipedia.org/wiki/Fitch_Ratings#cite_note-2011_Fiscal_Report-1

мөнгөний бодлогын байдлыг үнэлснээр зээл төлөх чадвар буюу зээлжих чадварыг үнэлж болох юм гэж үзсэн байна.

Тухайн улсын зээлжих зэрэглэлийг тодорхойлогч индикатор

Moody's болон Standard and Poor's 2 зэрэглэлийн хүчин зүйлийн тайландаа тухайн улсын зээлжилтийн зэрэглэлийг гаргахад нөлөөлдөг олон тооны эдийн засгийн, нийгмийн, улс төрийн хүчин зүйлүүдийг оруулсан байдаг. Зарим хүчин зүйлс нь тоон үзүүлэлт биш учраас хүчин зүйлс болон бодит үнэлгээ 2-ын хамаарлыг тодорхойлох нь хэцүү байдаг. Хүчин зүйл тус бүрийн харьцангуй жинг тодорхойлсон баримтаар агентлагууд сайн хангаж чаддаггүй.

Тухайн улсын зэрэглэлийг тодорхойлогч хэмээн зэрэглэл тогтоогч агентлагуудын тайланд давтагддаг дараах хувьсагчууд байдаг.

Хүснэгт 2. Зээлжих зэрэглэлийг тодорхойлогч хүчин зүйлс

Хувьсагчийн нэр	Тайлбар	Нэгж	Эх сурвалж
Нэг хүнд ноогдох орлого	Нэг хүнд ноогдох ҮНБ - хэмжээ	Мянган доллар	Worldbank
ДНБ	ДНБ	тэр бум доллар	Worldbank
ДНБ - ий өсөлт (жилийн дундаж)	ДНБ-ий жилийн дундаж өсөлт	%	Worldbank
Инфляци	Жилийн дундаж инфляциин түвшин	%	Worldbank , IMF
Чанаргүй зээлийн түвшин	Нийт зээлд эзлэх найдваргүй зээлийн түвшин	%	Worldbank
Санхүүгийн тэнцэл	ЗГ-ын төсвийн тэнцлийг ДНБ -нд харьцуулсан	%	Worldbank ,IMF
Гадаад тэнцэл	Гадаад төлбөр тооцооны тэнцлийг ДНБ -нд харьцуулсан	%	Worldbank,IMF
Гадаад өр (Экспортод харьцуулсан)	Гадаад валютын өрийг экспортод харьцуулсан	%	Worldbank
Ажилгүйдлийн түвшин	Ажилгүйдлийн түвшин	%	Worldbank

Дундаж наслалт			Worldbank
Хөгжиж буй орон эсэх	Аж үйлдвэржсэн орны зэрэглэл	0 ба 1	IMF
Зээл төлөлтийн түүх	Гадаад валютын өрөө төлөөгүй эсэх	0 ба 1	IMF
Moody's ,S&P , avg rating	Зээлжих зэрэглэл	1 ээс 16	Moody's , S&P

Эх сурвалж: Moody's, Standart and Poor's, Fitch

Монгол улсын зээлжих зэрэглэл

Эдийн засгийн өсөлт саарсан, төсвийн алдагдал нэмэгдсэн, өрийн хэмжээ өсч байгаагаас шалтгаалан Монгол Улсын зээлжих зэрэглэлийг S&P агентлаг 2015 оны 11 дүгээр сард “B+” зэрэглэлээс бууруулж “B”, Moody's B2, Fitch “B” гэж тус тус үнэллээ. Ийнхүү зээлжих зэрэглэлийг бууруулан үнэлэх болсон гол шалтгааныг манай улсын эдийн засаг хөрөнгө оруулалтын таатай бус нөхцөл байдалтай байгаа, өх,зах зээл эрсдэлтэй байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Хүснэгт 3. Монгол улсын зээлжих зэрэглэл 2016.04.16-ны байдлаар

	S&P	Moody's	Fitch
Зэрэглэл	B	B2	B
Ирээдүйн төлөв	Тогтвортой	Сөрөг	Тогтвортой

Эх сурвалж: <http://www.tradingeconomics.com/mongolia/rating>

Сүүлийн 10 жилийн байдлаар Монгол улсын зээлжих зэрэглэл дараах байдалтай байна.

Агентлаг	Зэрэглэл	Төлөв байдал	Хугацаа
TE	36	тогтвортой	Apr 16 2016
Fitch	B	тогтвортой	Nov 24 2015
S&P	B	тогтвортой	Nov 03 2015
S&P	B+	сөрөг	Apr 29 2015
Moody's	B2	сөрөг	Jul 17 2014
Moody's	B1	сөрөг	May 26 2014
S&P	B+	тогтвортой	Apr 29 2014
Fitch	B+	сөрөг	Dec 13 2013
S&P	BB-	сөрөг	Apr 16 2013
S&P	BB-	тогтвортой	Oct 29 2012

S&P	BB-	ээрэг	Dec 19 2011
Fitch	B+	тогтвортой	Nov 23 2010
S&P	BB-	тогтвортой	Nov 20 2009
Moody's	B1	тогтвортой	Oct 30 2009
Fitch	B	тогтвортой	Oct 11 2009
Moody's	B1	сөрөг	Jun 10 2009
Moody's	B1	сөрөг	Feb 05 2009
Fitch	B	сөрөг	Jan 19 2009
S&P	BB-	сөрөг	Dec 19 2008
Fitch	B+	сөрөг	Dec 10 2008
Fitch	B+	тогтвортой	Jun 03 2008
S&P	BB-	тогтвортой	Dec 13 2007
Fitch	B+	ээрэг	Sep 20 2007
S&P	B+	ээрэг	Dec 22 2006

Эх сурвалж: <http://www.tradingeconomics.com/mongolia/rating>

Улсын зээлжих зэрэглэл нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд санхүүгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татахад нөлөөтэй үзүүлэлтийн нэг байдаг.

Аж ахуй нэгжийн зэрэглэл: Хэрэв та компанид хөрөнгө оруулалт хийх эсэхийг шийдэхээс өмнө та ирээдүйд тухайн аж ахуйн нэгж нь хүлээсэн үүргээ биелүүлж чадах эсэхийг судлах хэрэгтэй.

Зэрэглэл тогтоох гэдэг нь өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдад тухайн орны эсвэл аж ахуйн нэгжийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад ямар эрсдэлтэй вэ гэдгийг харуулдаг зээлийн эргэн төлөлтийн хувьд зохистой, хараат бус, бодитой үнэлгээ өгч байгаа хөндлөнгийн эрх бүхий байгууллагын дүгнэлт юм¹⁰. Өөрөөр хэлбэл, компанийн урт, богино хугацаатай өрийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад харах голлох санхүүгийн үзүүлэлт юм.

¹⁰ <http://www.investopedia.com/articles/03/102203.asp#ixzz46ukOvTU8>

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООЛГОХ ДАВУУ ТАЛ¹¹



Сул тал

- ✓ Гажуудуулах магадлалтай
- ✓ Нийгмийн өөрчлөлтийн нөлөө
- ✓ Шинэ компанийн хувьд асуудалтай
- ✓ Зэрэглэлийн бууралт
- ✓ Ялгаатай зэрэглэлээрэг нь компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Аж ахуй нэгжийн зэрэглэл тогтоох шинжүүр

Бизнесийн эрсдэлийн шинжилгээ

Санхүүгийн шинжилгээ

Бусад шинжилгээ (Газар зүйн болон суурь шинжилгээ)-г хийж зэрэглэлийг тогтоодог. Үүнд:

✓ Бизнесийн шинжилгээ

Улсын болон макро эдийн засгийн эрсдэл

Эдийн засгийн эрсдэл

Өрсөлдөөний байр суурь:

- Зах зээлд эзлэх байр суурь
- Диверсификаци
- Үйл ажиллагааны үр ашигт байдал

¹¹ Floyd Saunders: "Figuring Out Wall Street: Consumer's Guide to Financial Markets"

✓ **Санхүүгийн шинжилгээ**

Нягтлан бодох бүртгэлийн чанар

Мөнгөний урсгал

Капиталын бүтэц

Удирдлагын дүгнэлт

- ✓ Компанийн үзүүлэлт нь:
- ✓ Удирдлагын зорилго, төлөвлөгөө, стратеги
- ✓ Ажилчдын туршлага, ур чадвар, төлөвлөх ба хянах систем
- ✓ Гэнэтийн нөхцөл байдлыг даван туулах чадвар байдаг

Зэрэглэл тогтоогч байгууллага бүр өөр, өөрийн тодорхой үе шаттай судалгаа шинжилгээгээ хийдэг.

График 2. Зэрэглэл тогтоох үе шат



Эх сурвалж: Standard and Poor's "Sovereign Credit Rating Methodology"

Зэрэглэл тогтоох нь хөрөнгийн зах зээлд нөлөөлөх нь

Зээлжих зэрэглэлийг тогтоох нь хөрөнгийн зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг таамаглахад хүндрэлтэй байдаг. Гэхдээ хөрөнгө оруулагчид компанийн зээлээ төлөх чадварын өөрчлөлтийг сайн хянаж чадвал ашгаа бууруулахгүй байх боломжтой.


Дэлхийн зэрэглэл тогтоогч агентлагууд нь зах зээлийг шинэ мэдээллээр хангаж байдаг. Гэвч зэрэглэлд үзүүлэх зах зээлийн хариу үйлдэл нь агентлагуудын үйл ажиллагаанаас үл хамааран өөр өөр байдаг.

Зах зээл нь зэрэглэлийн бууралтаас илүү өсөлтөнд хариу үйлдэл үзүүлдэг.

Зэрэглэл өсч байгаа гэсэн мэдэгдэл нь зах зээлд эерэг хандлагыг бий болгодог. Гэхдээ харагдах байдал нь эерэг байлаа гээд бүтээгдэхүүний үнэнд богино болон урт хугацаанд аль алинд нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй.

МХБиржидбүртгэлтэй компаниудад тогтоосон зэрэглэл¹²

График 3. МХБ-ийн компаниудын зэрэглэл тогтоох аргачлал



Эх сурвалж: mse.mn

МХБ-д бүртгэлтэй компаниудаас I-р ангилалд багтах компани одоогоор байхгүй байна. II-ангилалд-87, III-ангилалд 148 компани бүртгэлтэй байгаа. Энэ нь хөрөнгө оруулагчийн зүгээс манай хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа компаниудад хөрөнгө оруулалт хийхэд эрсдэлтэй гэдгийг харуулж байна.

¹² <http://mse.mn/>

Манай улсад мөнгөний зах зээл давамгайлдаг нөгөө талаар олон улсын зах зээлээс хөрөнгө татсан учраас томоохон арилжааны банкууд нэр хүнд бүхий агентуудаар зэрэглэлээ тогтоолгосон байдаг.

Хүснэгт 4. Монголын банкуудын зээлжих зэрэглэл

БАНКНЫ НЭР	S&P	MOODY'S	FITCH
Хөгжлийн банк	B	B2	-
ХХБанк	B	B3	-
Голомт банк	B	B2	-
ХААН банк	-	B2	B
Хас банк	-	B2	B
Төрийн банк	-	B3	B

Эх сурвалж: Банкуудын вэб хуудас

Олон улсын санхүүгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татахад компани зээлжих зэрэглэлээ тогтоолгох зайлшгүй шаардлагатай байдаг нь дээрх судалгааны ажлаас харагдаж байна.

Дүгнэлт

Орчин үед улс орнуудын эдийн засгийн өсөлт дотоод болон гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай болжээ. Засгийн газар болон компаниуд зайлшгүй шаардлагатай санхүүгийн Эх сурвалжийг бий болгох хамгийн оновчтой талбарыг хөрөнгийн зах зээл гэж үзэж байна. Монгол улсын хувьд эдийн засгийн тогтвортой хөгжилт өсөлтөд хүрэх, тэр нь иргэдэд хүртээмжтэй байх, зээлийн хүүг бууруулах зэрэгт зээлжих зэрэглэл чухал ач холбогдолтой.

Гэвч сүүлийн жилүүдэд манай улсын хөрөнгө оруулалтын зэрэглэл эрсдэлтэй ангилалд багтаж зээлжих чадвар доогуур үнэлэгдэж байгаагаас хөрөнгө оруулалтын зардал өндөр өртөгтэй байна.

Манай улсын санхүүгийн байгуулагуудаас Хөгжлийн банк, арилжааны 5 банк тус тус олон улсын мэргэжлийн байгуулагуудаар зээлжих зэрэглэлээ тогтоолгосон байдаг. Үүнээс харахад манай компаниуд зээлжих зэрэглэл тогтоолгох үйлчилгээг хангалттай авч чадахгүй байна.

Манай компаниудын хувьд санхүүгийн зах зээлээс үнэ /өртөг/ багатай хөрөнгө босгох боломжийг бүрдүүлэхийн тулд зэрэглэл тогтоох үйлчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэх шаардлагатай байна. Иймд эхний ээлжинд дотоодын

эрх бүхий зэрэглэл тогтоох мэргэжлийн байгууллагаар зэрэглэлээ тогтоолгон, түүний үндсэн дээр өөрийн үйл ажиллагаагаа сайжруулах түүнчлэн зэрэглээ ахиулах нь ач холбогдол бүхий чухал асуудал болж байна.

Ашигласан материал

Floyd Saunders: “Figuring Out Wall Street: Consumer’s Guide to Financial Markets”

Standard and Poor’s agency, “Sovereign Government Rating Methodology And Assumptions” June, 2011

“Sovereign Bond Ratings” Moody’s agency-2008

<http://www.tradingeconomics.com/mongolia/rating>

<https://www.fitchratings.com/>

<http://www.standardandpoors.com/>

<https://www.moody.com/>

<http://www.investopedia.com/articles/03/102203.asp#ixzz46ukOvTU8>

<http://mse.mn/>

<https://www.khanbank.com/>

<http://www.xacbank.mn/>

<http://www.tdbm.mn/mn/>

<http://www.golomtbank.com/>

<http://www.statebank.mn/>

https://en.wikipedia.org/wiki/Fitch_Ratings#cite_note-2011_Fiscal_Report-1

“Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам” 2013он